

ЖИЛИЙН ТАЙЛАН
2015

БИДНИЙ ТУХАЙ




АЛСЫН ХАРАА

Бид Монголдоо дэлхийн түвшний санхүүгийн үйлчилгээтэй байгууллага болно.




ЭРХЭМ ЗОРИЛГО

Эрдэнэт хүмүүн, Эх дэлхий, Эрүүл ашгийг эрхэмлэн харилцагчиддаа үнэ цэнэтэй санхүүгийн үйлчилгээг хүргэж, насан туршийн түнш нь байх болно.



ҮНЭТ ЗҮЙЛС



СТРАТЕГИ



Шинэчилсэн стратеги маань хэмжээгээрээ бус ашгаараа тэргүүлэгч, санхүүгийн цогц үйлчилгээний томоохон нэгдэл болох үндсэн чиг зорилтыг шингээж ажиллана. Мөн илт ялгарах үнэ цэнэ бүхий харилцагчид төвлөрсөн стратегийн ач тусаар зах зээлд эзлэх байр сууриа улам бэхжүүлж иргэд болон дунд ба томоохон жижиг дунд үйлдвэрлэгч, сонгомол харилцагчдад нэгэн зэрэг санхүүгийн үйлчилгээ үзүүлэн ашигт ажиллагааг хангахад оршино.



ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН МЭНДЧИЛГЭЭ

“Тэнгэр Даатгал” компанийн хувьд өнгөрсөн жил менежментийн болон бүтцийн өөрчлөлт хийж, дотоод удирдлагын бүтцээ шинэчилж, зах зээлийн хэцүү нөхцөлийг туулсан сорилтын жил байлаа. Гэсэн хэдий ч бидний хувьд 400 гаруй сая төгрөгийн ашигтай ажиллаж, нийт хөрөнгөө 13 хувиар, хураамжийг 6 хувиар өсгөсөн амжилттай жил болж өнгөрлөө.

Бидний үзүүлж буй даатгалын үйлчилгээ нь давхар даатгалын чанар, найдвартай байдлаараа олон улсын стандартад нийцэж, зах зээлийн хөгжилд өөрсдийн хувь нэмрийг орууллаа. Бид олон улсын хамтын ажиллагааны хүрээнд өөрсдийн санал болгож буй бүтээгдэхүүн үйлчилгээгээ сайжруулах болон андеррайтингийн чадвар, даатгалын салбарт гаргасан санаачлага, мэдлэгээрээ бусад даатгалын үйл ажиллагаа эрхэлдэг компаниудад жишиг, хэм хэмжээ тогтоохоор зорьж байна.

Манай компани нь байгууллагуудад эд хөрөнгө, гэнэтийн осол, эрүүл мэнд, санхүүгийн даатгалын чиглээр, иргэдийн хувьд тээврийн хэрэгсэл, хувийн эд хөрөнгийн даатгалаар тус тус мэргэшсэн андеррайтерын багаар дамжуулан үйлчилгээ үзүүлдэг цорын ганц даатгалын компани юм.

2013 онд “Тэнгэр Санхүүгийн Нэгдэл”-ийн 100 хувийн хөрөнгө оруулалтыг авсанаас хойш тус компанийн бизнесийн байр суурь огцом нэмэгдэж, харилцагч, хувь хүн, хамтрагч, түншүүддээ үзүүлж буй банк, санхүү, даатгалын үйлчилгээний өсөлтөд хүчтэй нөлөө үзүүлж, Монголын санхүүгийн салбарт шинэ стандарт нэвтрүүлсэн.

Бид 24/7 дуудлагын төвөөрөө дамжуулан нөхөн төлбөрийн чадвараа цаашид улам сайжруулахаар зорьж байна. Бүтээгдэхүүн бүрээр нөхөн төлбөрийн шийдвэрлэлт болон хохирлын харьцааны хяналтад системтэй дүн шинжилгээ хийж ажилладаг нь “ухаалаг, бас хурдан” буюу чанартай даатгалын үйлчилгээ үзүүлэх үндэс суурь нь болдог.

Актуар болон эрсдэлийн удирдлага нь манай компанийн хувьд өндөр ач холбогдол бүхий үйл ажиллагаа бөгөөд бид мэргэжлийн ур чадвар, салбарын мэдлэг туршлагад тулгуурлан харилцагчдынхаа итгэлийг олоход чиглэж ажилладаг. Харилцагчийн үйлчилгээний чанар, санхүүгийн тогтвортой байдал, цаг хугацаанд нь нөхөн төлбөрийг шийдвэрлэх зэрэг нь бидний амжилтын хамгийн чухал үзүүлэлтүүд юм.

Бид ажиллагсдынхаа мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх үүднээс дотоод болон олон улсын сургалтуудад хамруулсаар байна.

2015 онд манай байгууллага МҮХАҮ-ийн танхимаас зохион байгуулдаг “Энтрепренер” арга хэмжээнээс “Оны Шилдэг Даатгалын Компани”, “Global Banking & Finance Review”-ээс 2015 оны “Шилдэг Онлайн Даатгал”-ын компани зэрэг хэд хэдэн шагнал авсан бөгөөд мөн манай ажилтнууд хөдөлмөрийн хүндэт медаль, Банк, санхүүгийн салбарын тэргүүний ажилтан, Сангийн яамны жуух бичиг, Санхүүгийн зохицуулах хорооны жуух бичиг, залуучуудын холбооны медаль зэрэг шагналуудыг хүртлээ.

Би тус компанийн гүйцэтгэх захирлын хувьд Монгол улсын даатгалын салбарт жишиг тогтоож, Тэнгэр Даатгал компанийг үр ашигтай, нэр хүндтэй компани болгохоор зорьж ажиллах болно.

Ойбек Н.Халилов





Гүйцэтгэх Захирал



САНХҮҮГИЙН ГОЛЛОХ
ҮЗҮҮЛЭЛТҮҮД

САНХҮҮГИЙН ГОЛЛОХ ҮЗҮҮЛЭЛТҮҮД

ЗАХ ЗЭЭЛИЙН МЭДЭЭЛЭЛ
сая.төг



БОРЛУУЛАЛТЫН СУВАГ

2015 онд нийт эдийн засгийн өсөлт удааширч бизнесийн орчны бүх шатанд нөлөөлж байгаа хэдий ч компанийн орлогод тооцсон хураамж өмнөх жилээс 0.6 тэрбум төгрөгөөр өсч нийт 6.4 тэрбум төгрөгт хүргэсэн амжилттай байна. Энэхүү хураамжийн өсөлтөд банк болон брокерын даатгалын дамжуулан борлуулалт тус тус 60% ба 20% нэмэгдсэн нь өсөлтийн гол хүчин зүйл нь болсон.

НӨХӨН ТӨЛБӨР

2015 онд нийт нөхөн төлбөрийн хэмжээ 622 сая төгрөгөөр (23%) нэмэгдэж 2.8 тэрбум төгрөгт хүрэв. Өмнөх жилийн хувьд жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын борлуулалтын өсөлт, мөн тус даатгалын хохирлын давтамж эрс нэмэгдсэнээс үүдэн нийт хохирлын нөхөн төлбөрийн зардал 49 хувь буюу 387 сая төгрөгөөр өсөснөөр тус бүтээгдэхүүний хохирлын харьцаа 70 хувьд хүрсэн байна.

Үүнээс улбаалан компанийн хохирлын харьцаа тайлант жилд 43 хувьд хүрч 2014 онтой харьцуулахад 6.4 хувийн пунктээр өссөн үзүүлэлттэй тайлант жилийг өндөрлөлөө.

АШИГТ АЖИЛЛАГАА

2015 онд бид 412 сая төгрөгийн цэвэр ашиг, 9 хувийн өөрийн хөрөнгийн өгөөжтэй ажиллалаа. Зайлшгүй байгуулах даатгалын нөөц сан, орлогод тооцсон хураамжаас олгох нөхөн төлбөрийн зардал, мөн нэмээд даатгалын бизнес эрхлэхэд зайлшгүй гарах үйл ажиллагааны зардал өсч байгаа нь ашигт ажиллагаанд сөргөөр нөлөөлсөн.

Зардлын нийлмэл харьцаа 2012 оноос өссөөр 2015 онд 105.4 хувьд хүрэв.


САНХҮҮГИЙН ГОЛЛОХ ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Нийт хөрөнгө 13 хувиар нэмэгдэж нийт 4 жилийн дундаж нийлмэл өсөлт 23 хувьтай байгаа нь даатгалын нөөц сан, өөрийн хөрөнгө тус тус 12 ба 6 хувиар өссөнтэй холбоотой.


Санхүүгийн зах зээлийн хүү өсч байгаагийн үр дүнд богино хугацаат хөрөнгө оруулалтын орлогоо 21 хувиар нэмэгдүүлээ.

Төлбөрийн чадварын харьцаа үзүүлэлт 2015 оны эцэст 105 хувьд хүрч 4 жилийн дундаж үзүүлэлт 118 хувь болсон нь Тэнгэр Даатгал компани санхүүгийн тогтвортой байдлыг богино хугацааны ашгаас илүү өндөрт тавьж ажилладгийг илэрхийлж улмаар өөрийн харилцагч болон хамтрагч түнш байгууллага, компаниудын итгэх итгэлийг нэмэгдүүлсээр ирлээ.


Эдийн засгийн чадамж хумигдсаар буй энэ орчинд зах зээлийн өрсөлдөөн улам ширүүсч буй хэдий ч бид бизнесийн дэд бүтцийнхээ давуу талыг ашиглан даатгалын зуучлалын зардлыг 12.1 хувьд тогтоож чадлаа.



Нийт хураамж (сувгаар)



Нийт хураамж (бүтээгдэхүүнээр)



ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДАЛ

Тэнгэр Даатгал ХХК нь харилцагчиддаа эрсдлийн удирдлагын цогц шийдлийг санал болгож, хариуцлага, ил тод байдал, компанийн засаглалаараа тэдний итгэлийг олсон салбартаа тэргүүлэгч байгууллага юм.

- Бид олон улсын жишигт нийцсэн бүтээгдэхүүн үйлчилгээ санал болгодог.
- Эрсдэлийг бууруулах чиглэлээр зөвлөгөө өгөх, эрсдэлийн удирдлагын сургалт явуулах, боломжит эрсдэлүүдийг тодорхойлох, бууруулах, арилгах чиглэлээр аюулгүй байдлын зөвлөгөө өгөх зэргээр бид эрсдэлийн шилдэг шийдлийг санал болгодог.

Бид өөрсдийн 22 салбар, даатгалын төлөөлөгч, банк болон даатгалын брокерийн компаниудаар дамжуулан даатгалын үйлчилгээ үзүүлж байна. 2015 оны стратегийн нэг хэсэг болох олон улсын стандартад нийцсэн даатгалын бүтээгдэхүүн үйлчилгээ санал болгох зорилтынхоо хүрээнд байгууллага, арилжааны болон иргэдийн зах зээлд чиглэн ажиллаж байна.


Тэнгэр Даатгал ХХК нь өсөн нэмэгдэж буй байгууллагын зах зээлд тэргүүлэгч байгууллага юм. Байгууллагын харилцагчдын тоо 11,700-д хүрч 19 хувиар нэмэгдсэн үзүүлэлттэй байна. Даатгуулсан иргэдийн тоо 61,000-д хүрч 26 хувиар өссөн байна.

Бид тайлант хугацаанд дотоодын болон олон улсын хэд хэдэн нээлттэй тендерт оролцож гэрээгээр хүлээсэн үүргийнхээ хүрээнд даатгалын үйлчилгээ санал болгож ажилласан.

Эрсдлийн удирдлага, эрүүл мэнд болон аюулгүй байдлын сургалтыг 120 байгууллага, жижиг, дунд бизнес эрхлэгчдийн дунд зохион байгуулсан.

Тэнгэр Даатгал ХХК-ийн иргэдийн зах зээлийн стратегийн хүрээнд зорилтот сегментийн харилцагчид болон банкаар дамжуулах даатгалын үйлчилгээнд чиглэж зах зээлд эзлэх хувиа нэмэгдүүлнэ. Бид 200 гаруй төлөөлөгч, даатгалын брокер, арилжааны банкуудтай хамтран ажиллаж үйлчилгээгээ хүргэж байна. Бид банкаар дамжуулан 29,500 гаруй даатгалын гэрээ хийсэн бөгөөд энэ нь 112 хувиар өссөн үзүүлэлт юм.

САЛБАРУУД





БҮТЭЭГДЭХҮҮН

Гэнэтийн осол эрүүл мэндийн даатгал

- Ажиллагсдын гэнэтийн осол
- Иргэдийн гэнэтийн осол
- Нисэх онгоцны багийн гэнэтийн осол
- Зорчигчийн гэнэтийн осол
- Нисэх онгоцны зорчигчдын гэнэтийн осол
- Хурдан морь унаач хүүхдийн гэнэтийн осол
- Хүүхдийн гэнэтийн осол
- Хувийн эрүүл мэндийн даатгал
- Олон Улсын эрүүл мэндийн даатгал
- Жаргалтай иргэн даатгал
- Гадаадад зорчигчийн гэнэтийн осол эрүүл мэндийн даатгал
- Гадаадаас зорчигчдын гэнэтийн осол эрүүл мэндийн даатгал

Хариуцлагын даатгал

- Эмнэлэгийн ажиллагсдын мэргэжлийн хариуцлагын даатгал
- Мэргэжлийн хариуцлагын даатгал
- Архитекторчдын мэргэжлийн хариуцлагын даатгал
- Аудиторын мэргэжлийн хариуцлагын даатгал
- Өмгөөлөгч болон нотариатчдын мэргэжлийн хариуцлагын даатгал
- Хуулийн хариуцлагын даатгал
- Шатахуун тээвэрлэгчийн хариуцлагын даатгал
- Хүн тээвэрлэгчийн хариуцлагын даатгал
- Ачаа тээвэрлэгчийн хариуцлагын даатгал
- Байгууллагын хариуцлагын даатгал
- Зочид буудлын хариуцлагын даатгал
- Олон нийтийн өмнө хүлээх хариуцлагын даатгал
- Бүтээгдэхүүний хариуцлагын даатгал
- Ажил олгогчийн хариуцлагын даатгал
- Нисэх буудлын хариуцлагын даатгал
- Байгаль орчны хариуцлагын даатгал

Тээврийн хэрэгслийн даатгал

- Тээврийн хэрэгслийн даатгал
- Тээврийн хэрэгслийн нэг эрсдэлийн даатгал
- Хүнд даацын тээврийн хэрэгслийн даатгал

Жолоочийн хариуцлагын албан журмын даатгал

- Жолоочийн хариуцлагын даатгал
- Мэргэшсэн жолоочийн хариуцлагын даатгал

Жолоочийн хариуцлагын даатгал

- Жолоочийн хариуцлагын даатгал /Сайн дурын/
- Жолоочийн хариуцлагын даатгал /GREENCARD/

Барилга угсралтын даатгал

- Барилга угсралтын даатгал

Хөрөнгийн даатгал

- Эд хөрөнгийн даатгал
- Байшин барилгын даатгал
- Бараа материалын даатгал
- Хүнд машин механизмийн даатгал
- Тонго төхөөрөмжийн даатгал
- Суурилуулдаггүй ТТ-ийн даатгал
- Газрын тосны бүтээгдэхүүний даатгал
- Шуудан илгээмжийн даатгал
- Барьцаа хөрөнгийн даатгал

Санхүүгийн даатгал

- Бизнес тасалдлын даатгал
- Бэлэн мөнгөний даатгал
- Цахим гэмт хэргийн даатгал
- Банкны бүрэн баталгааны даатгал
- Удирдах ажилтны хариуцлагын даатгал
- Тэрроризмын даатгал
- Гэмт хэргийн даатгал
- Ашиглалтын баталгааны даатгал

Агаарын хөлгийн даатгал

- Агаарын хөлгийн их биеийн даатгал

Агаарын хөлгийн хариуцлагын даатгал

- Агаарын хөлгийн хариуцлагын даатгал

Ачаа тээврийн даатгал

- Гадаад ачааны даатгал
- Дотоод ачааны даатгал

Итгэлцлийн даатгал

- Гэрээний хариуцлагын даатгал
- Чин шударгын баталгааны даатгал
- Урьдчилгаа төлбөрийн баталгааны даатгал

Зээлийн даатгал

- Зээлийн төлбөр тасалдлын даатгал
- Зээлийн эрсдэлийн даатгал

Мал амьтадын даатгал

- Малын даатгал
- Амьтадын даатгал
- Хурдан морины даатгал

Газар тариалангийн даатгал

- Үр тарианы даатгал



ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ
ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДАЛ

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДАЛ

Монгол Улсын даатгалын зах зээл дээрх анхны цогц Даатгалын үндсэн системийг “Тэнгэр Даатгал” үйл ажиллагаандаа бүрэн ашиглаж байна.

Дэлхий нийтийн болон Тэнгэр Санхүүгийн Нэгдлийн Мэдээлэл Технологийн аюулгүй байдлыг сайжруулах чиг хандлагад нийцүүлэн компани бизнесийн тасалдалгүй ажиллагааг хангах, мэдээлэл алдагдахаас урьдчилан сэргийлэх үүднээс нэмэлт нөөц сервер суурилуулав.

Даатгалын үндсэн системийн шинэчлэлтийг амжилттай хэрэгжүүлж дараах давуу талуудыг бий болгож байна:

- Веб-д суурилсан программ нь хаанаас ч интернетээр дамжуулан олон төрлийн хэрэглэгч нэвтрэх боломжийг бүрдүүлнэ.
- Тайлагналт, дүн шинжилгээ, дата боловсруулалт сайжирна.
- Бизнесийн процессийн бүх түвшинд, төрөл болгонд бүрэн мэдээлэл оруулах боломжтой.
- Мэдээлэл боловсруулалт, ашиглалтыг сайжруулснаар Удирдлагын Мэдээллийн систем илүү боловсронгуй болно.
- Нөхөн төлбөрийн шийдвэрлэлтийн хугацааг онлайн хэлбэрт оруулснаар богинсоно.

Төрийн зохицуулах байгууллагаас гаргасан шинэ шаардлагын дагуу Тэнгэр Даатгал нягтлан бодох бүртгэл болон санхүүгийн тайлагналын шинэ дүрмийг үндсэн системдээ бүрэн нэвтрүүлээ. Олон улсын стандартуудыг үйл ажиллагаандаа мөрдөж ажилладгийн хувьд хөндлөнгийн аудитын ОУ-ын хамгийн том-4 гэх компаниудаар 2010 оноос хойш аудитлагдаж ирсэний хувьд бусад даатгалын компаниудтай харьцуулахад манай компани даатгалын зах зээлийн тэргүүн эгнээнд жагсахаар байна. Даатгалын нягтлан бодох бүртгэлийг ОУНББС-д илүү ойртуулж өөрчилсөн нь зах зээлийн ил тод байдал, дэг журмыг нэмэгдүүлж дотоод болон гадаад даатгалын компаниудтай харьцуулан жиших, дүн шинжилгээ хийх боломжийг олгож байна.


МАНАЙ ТҮНШҮҮД

Тэнгэр Даатгал ХХК нь олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн, нэр хүнтэй, туршлагатай, А+ буюу түүнээс дээш үнэлгээтэй давхар даатгагч нараар давхар даатгуулдаг.



НӨХӨН ТӨЛБӨРИЙН ШИЙДВЭРЛЭЛТ

2015 он Нөхөн төлбөрийн хэлтэсийн хувьд үйлчилгээний түвшинг олон улсын стандартад нийцүүлэх, 24 цагийн туршид даатгалын тохиолдлыг бүртгэх, нөхөн төлбөрийн шийдвэрлэлтийн хугацааг ажлын 5 өдөрт болгож бууруулах зэрэг томоохон үүрэг гүйцэтгэсэн жил байлаа. Жишээлбэл: Жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын нөхөн төлбөрийн шийдвэрлэлтийн дундаж хугацааг 4.8 ажлын өдөр, тээврийн хэрэгсэлийн даатгалын нөхөн төлбөрийн шийдвэрлэлтийг 6.0 ажлын өдөр, эд хөрөнгийн даатгалын нөхөн төлбөрийн шийдвэрлэлтийг 5.6-6.5 ажлын өдөр болгож тус тус бууруулсан. Компанийн нийт нөхөн төлбөрийн шийдвэрлэлтийн дундаж хугацаа нь 5.2 ажлын өдөр болж буурсан үзүүлэлттэй байна.



Харилцагчдынхаа цаг хугацааг хэмнэх, өндөр түвшний үйлчилгээ үзүүлэх зорилтын хүрээнд манай Нөхөн төлбөрийн хэлтэс Улсын их дэлгүүр, банк, санхүүгийн байгууллагууд болон Авто тээврийн үндэсний төвийн ойролцоо байршсанаар харилцагчдын хэрэгцээ шаардлагад нийцэж байна.


Тайлант хугацаанд Тэнгэр Даатгал ХХК нь 4,308 даатгуулагчид нийт 2,78 тэрбум төгрөгийн нөхөн төлбөрийг олгосон байна. Нийт нөхөн төлбөр олговорын 41 хувийг Жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын нөхөн төлбөр эзлэж байна. 2012 онд Жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын тухай хууль хэрэгжиж эхэлсэнээс хойш нөхөн төлбөрийн хэмжээ 2 дахин нэмэгдсэн.

АКТУАР

Манай актуарч нь Санхүүгийн Зохицуулах Хорооны лицензтэй бөгөөд Их Британийн Актуарын Институт, Факултетын гишүүн юм. Энэ нь манай харилцагчдын хувьд даатгалын хураамжыг зөв тооцоолох, байгууллагын хувьд нөөцийг хангалттай бүрдүүлэх, төлбөрийн чадварын үзүүлэлтийг хангалттай түвшинд барих боломжуудыг олгодог.

Дээрх шаардлагуудыг биелүүлэх үүднээс компанийн актуарчидад зориулсан олон улсын мэргэжлийн сургалт болон шалгалтанд бэлтгэх цогц сургалтыг байнга зохион байгуулж ирсэн. 2015 оны намар манай актуарч Казахстан улсад зохион байгуулагдсан олон улсын даатгалын зах зээлд шинээр хэрэгжүүлэх "Төлбөрийн чадвар II" стандартын талаарх мэргэжлийн сургалтад хамрагдсан. Энэхүү стандарт нь харилцагчид чиглэсэн даатгалын зах зээлийг шинэ түвшинд авчрах юм.

■ Нөөц сан ■ Нөхөн төлбөр



Компани нь нөөцийн санг тодорхойлох, хуваарилахтай холбоотойгоор Санхүүгийн Зохицуулах Хорооноос тогтоосон нөөц, төлбөрийн чадварын шаардлагад нийцүүлэн ажилладаг бөгөөд олон улсын аргачлалыг мөн авч хэрэгжүүлдэг. 2013 оноос хойш "Deloitte", "E&Y" зэрэг олон улсад нэр хүндтэй компаниуд манай нөөцийн санд аудит хийсэн бөгөөд улмаар биднийг Санхүүгийн Тайлагналын Олон Улсын стандартад нийцэж байгааг баталсан билээ.

2015 онд Тэнгэр Даатгал ХХК-ийн нийт нөөцийн сан нь 8 тэрбум төгрөгт хүрсэн. Монгол улсын даатгалын компаниудын дунд нийт нөөцийн сангаараа хоёрдугаарт байгаа нь манай компанийн чадамжийг бүрэн илэрхийлж байна. Бид энэүү чадамжид тулгуурлан харилцагчийн даатгалын нөхөн төлбөрийн асуудлыг 3-6 өдөрт багтаан шийдвэрлэж байна.

Хохирлын харьцаа өндөр, зах зээлийн дундаж хохирлын харьцаанд нөлөөлж буй жолоочийн хариуцлагын албан журмын даатгал зах зээлд нэвтэрсэнээр манай нөөцийн сан жилээс жилд нэмэгдэж байна.



ЭРСДЭЛИЙН
УДИРДЛАГА

ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА

Тайлант хугацаанд Тэнгэр Даатгал ХХК нь хохирлын харьцааг 43 хувиас доогуур барьж төлөвлөгөөгөө амжилттай хэрэгжүүллээ. Зарим даатгалын бүтээгдэхүүний хувьд улирлын шинж чанараас шалтгаалан хохирлын харьцаа тогтворгүй байсан бөгөөд энэ нь жилийн эцэст тэнцвэржсэн байна.

Тэнгэр Даатгал ХХК нь 2014 оноос хойш уул уурхай, барилга, худалдаа, үйлчилгээ, хүнс зэрэг төрөл бүрийн байгууллагын эрсдэлийг удирдах чиглэлээр мэргэжлийн байгууллагуудтай хамтарч ажилласаар ирсэн.

2015 онд харилцагчид, ажиллагсад, удирдлагуудад аюулгүй байдал, эрүүл ахуйн мэдлэг олгох үүднээс бид энэ чиглэлээр мэргэшсэн “Монголын хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн менежментийн хүрээлэн” ТББ-тай хамтран Улаанбаатар, Эрдэнэт, Дархан хотуудад байрлах аж үйлдвэрийн салбарын 100 гаруй байгууллагын удирдлагуудыг 4 цагийн цогц мэдлэг олгох сургалтад хамруулсан. Сургалтад хамрагдсан харилцагчдын санал хүсэлт нь даатгалын салбарт чухал ач холбогдолтой, харилцан уялдаатай ажиллах эх үндэс болж байлаа.

Эрдэнэт, Дархан хотод зохион байгуулсан сургалт нь орон нутгийн харилцагчдад анх удаа эрсдэлийн удирдлагын үйлчилгээ үзүүлсэн гэдгээрээ онцлог байсан.


Дээрх үүргийг хэрэгжүүлэхэд анхан шатны газар нэгж, байгууллагын зүгээс хүчин зүтгэл гаргаж ажилласны үр дүнд амжилтад хүрч, харилцагчдын талархалыг хүлээсэн.

ХАРИЛЦАГЧИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТӨВ

2015 оны 1-р сард Тэнгэр Даатгал ХХК нь даатгалын зах зээлд харилцагчийн үйлчилгээний шинэ эхлэлийг нэвтрүүлсэн.

- 24 цагийн үйлчилгээ
- Мэргэшсэн операторууд
- Зах зээлд өвөрмөц
- Даатгалын бүтээгдэхүүн, нөхөн төлбөрийн бүртгэл болон шаардлагатай бусад даатгалын асуудлын талаарх зөвлөгөө
- 12.5 мянга гаруй дуудлага хүлээн авсны 65 хувь нь даатгалын нөхөн төлбөрийн талаар байсан.





ХАРААТ БУС
АУДИТОРЫН ТАЙЛАН

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

Тэнгэр Даатгал ХХК-ийн Хувьцаа эзэмшигч танаа,

Бид Тэнгэр Даатгал ХХК (цаашид "Компани" гэх) -ийн 2015 оны 12 дугаар сарын 31-ний санхүүгийн байдлын тайлан, уг өдрөөр тасалбар болгосон тайлант жилийн иж бүрэн орлогын тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан болон нягтлан бодох бүртгэлийн бодлого, тайлбар тодруулгаас бүрдсэн санхүүгийн тайланд аудит хийлээ.

Санхүүгийн тайлантай холбоотой удирдлагын үүрэг

Удирдлага нь санхүүгийн тайлангаа Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартын Зөвлөлөөс гаргасан Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартын дагуу бэлтгэн шударгаар илэрхийлэх, эдгээр санхүүгийн тайланг алдаа эсвэл санаатай зальт үйлдлээс үүсэлтэй материаллаг хэмжээний зөрчилгүйгээр бэлтгэж, шударгаар илэрхийлэхийн тулд удирдлагаас шаардлагатай гэж тогтоосон дотоод хяналтыг хэрэгжүүлэх үүрэгтэй.

Аудиторын үүрэг

Аудитор хийсэн аудитдаа үндэслэн санхүүгийн тайланд дүгнэлт өгөх үүрэгтэй. Бид аудитаа Аудитын Олон Улсын стандартын дагуу гүйцэтгэсэн болно. Санхүүгийн тайлан нь материаллаг үзүүлэлтийнхээ хувьд алдаа зөрчилгүй гэдэг зохих магадлагаа олж авахуйцаар аудитыг төлөвлөж гүйцэтгэх ба ёс зүйн шаардлагуудыг дагаж мөрдөхийг эдгээр стандартуудад шаарддаг.

Аудит нь санхүүгийн тайлан дахь дүн болон тодруулгыг нотлох нотолгооны зүйлсийг олж авахын тулд гүйцэтгэдэг аудитын горимуудаас бүрдэнэ. Санхүүгийн тайлан алдаа болон санаатай зальт үйлдлийн улмаас материаллагаар зөрчилтэй илэрхийлэгдэх эрсдэлд өгсөн аудиторын үнэлгээнээс хамааран аудитын горимуудыг сонгодог. Аудитор эрсдэлийн үнэлгээ хийхдээ санхүүгийн тайлан бэлтгэх шударгаар тайлагнахад хэрэглэдэг дотоод хяналтыг судалдаг. Энэ нь зөвхөн тухайн нөхцөл байдалд тохирсон аудитын горимуудыг сонгохтой холбоотой бөгөөд аж ахуйн нэгжийн дотоод хяналтын үр дүнтэй байдлын талаар дүгнэлт өгөх зорилгогүй болно. Үүнээс гадна аудит нь удирдлагын мөрдөж буй нягтлан бодох бүртгэлийн бодлогын тохиромжтой эсэх, удирдлагын хийсэн нягтлан бодох бүртгэлийн урьдчилсан тооцоолол зохистой эсэх, санхүүгийн тайлангийн ерөнхий тайлагналын байдлыг үнэлэх ажлуудаас бүрддэг.

Бидний олж авсан аудитын нотлох зүйлс нь аудиторын дүгнэлт гаргах хангалттай ба зохистой үндэслэл болно гэж итгэж байна.

Дүгнэлт

Бид, Компанийн 2015 оны 12 дугаар сарын 31-ний санхүүгийн байдал, уг өдрөөр тасалбар болгосон санхүүгийн үр дүн болон мөнгөн гүйлгээг Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартуудын дагуу үнэн, шударгаар илэрхийлж байна гэж дүгнэж байна.

Хэрэглээний хязгаарлалт

Энэхүү тайлан нь хувьцаа эзэмшигчдийн хүсэлтийн дагуу зөвхөн Компанийн хувьцаа эзэмшигчдэд зориулагдсан ба аливаа нэгэн өөр зорилго агуулаагүй болно. Бид энэхүү тайлангийн агуулгын хүрээнд бусад этгээдийн өмнө үүрэг хариуцлага хүлээхгүй болно.


Шагдарсүрэнгийн Норжинбат

Захирал, МНБ

Делоитт Онч Аудит ХХК

2016 оны 3 дугаар сарын 14

Норжинбат



САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

ТЭНГЭР ДААТГАЛ ХХК
САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН
2015 ОНЫ 12 САРЫН 31
(МЯНГАН ТӨГРӨГӨӨР)

	2015	2014
ХӨРӨНГӨ		
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	1,184,236	948,214
Богино хугацаат хадгаламж ба засгийн газрын бонд	8,854,415	7,157,394
Дансны ба бусад авлага	799,846	1,278,727
Даатгалын гэрээний хойшлогдсон зардал	499,565	533,766
Давхар даатгагчийн орлогод тооцоогүй нөөц	992,233	824,129
Урьдчилж төлсөн зардал	99,421	87,112
Бараа материал	53,511	76,084
Үндсэн хөрөнгө	1,194,449	1,201,821
Биет бус хөрөнгө	3,557	6,377
Нийт хөрөнгө	13,681,233	12,113,624
ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		
Өр төлбөр		
Орлогод тооцоогүй хураамжийн нөөц	4,269,312	4,043,293
Учирсан боловч нэхэмжлээгүй хохирлын нөөц	2,033,982	1,659,162
Болзошгүй хохирлын нөөц	1,542,252	1,291,637
Дансны ба бусад өглөг	1,202,864	731,801
Орлогын албан татварын өглөг	16,038	16,468
Нийт өр төлбөр	9,064,448	7,742,361
Эздийн өмч		
Энгийн хувьцаа	3,500,000	3,500,000
Нэмж төлөгдсөн капитал	130,000	130,000
Хуримтлагдсан ашиг	986,785	741,263
	4,616,785	4,371,263
Нийт өр төлбөр ба эздийн өмч	13,681,233	12,113,624

ИЖ БҮРЭН ОРЛОГЫН ТАЙЛАН

ТЭНГЭР ДААТГАЛ ХХК
ИЖ БҮРЭН ОРЛОГЫН ТАЙЛАН
2015 ОНЫ 12 САРЫН 31
(МЯНГАН ТӨГРӨГӨӨР)

	2015	2014
ОРЛОГОД ТООЦСОН ЦЭВЭР ХУРААМЖ		
Даатгалын нийт орлогод тооцсон хураамж	8,187,281	7,989,912
Давхар даатгагчид ногдох хураамж	(1,781,154)	(2,159,107)
Орлогод тооцсон цэвэр хураамж	6,406,127	5,830,805
Нөхөн төлбөрийн зардал, цэвэр дүнгээр		
Нөхөн төлбөрийн зардал	(3,467,663)	(2,693,092)
Давхар даатгагчид ногдох нөхөн төлбөр	86,964	120,663
Нөхөн төлбөрийн зардал	(3,380,699)	(2,572,429)
Даатгалын үйл ажиллагааны цэвэр орлого	3,025,428	3,258,376
Санхүүгийн ба бусад орлого	1,522,088	1,268,912
Бусад (гарз) ба олз	(10,370)	(4,472)
Ерөнхий ба удирдлагын зардал	(3,996,556)	(3,672,930)
Татварын өмнөх ашиг	540,590	849,886
Орлогын татварын зардал	(128,401)	(109,510)
Цэвэр ашиг	412,189	740,376
Бусад иж бүрэн орлого	-	-
Нийт иж бүрэн орлого	412,189	740,376

ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

ТЭНГЭР ДААТГАЛ ХХК
ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН
2015 ОНЫ 12 САРЫН 31
(МЯНГАН ТӨГРӨГӨӨР)

	Энгийн хувьцаа	Нэмж төлөгдсөн капитал	Хуримтлагдсан ашиг	Нийт эздийн өмч
2014 оны 1-р сарын 1-ний үлдэгдэл	2,750,000	130,000	1,073,109	3,953,109
Тайлант жилийн нийт иж бүрэн орлого	-	-	740,376	740,376
Гаргасан хувьцаа	750,000	-	-	750,000
Зарласан ногдол ашиг	-	-	(1,072,222)	(1,072,222)
2014 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	3,500,000	130,000	741,263	4,371,263
Тайлант жилийн нийт иж бүрэн орлого	-	-	412,189	412,189
Зарласан ногдол ашиг	-	-	(166,667)	(166,667)
2015 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	3,500,000	130,000	986,785	4,616,785

МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

ТЭНГЭР ДААТГАЛ ХХК
МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН
2015 ОНЫ 12 САРЫН 31
(МЯНГАН ТӨГРӨГӨӨР)

	2015	2014
Цэвэр ашиг	412,189	740,376
Тохируурлагууд:		
Орлогын татварын зардал	128,401	109,510
Хүүгийн орлого	(1,319,859)	(1,095,100)
Элэгдэл ба хорогдлын зардал	130,810	109,113
Найдваргүй авлагын зардал	48,875	67,733
Үндсэн хөрөнгө данснаас хассаны гарз	7,076	11,743
Гадаад валютын ханшийн өөрчлөлтийн хэрэгжээгүй олз	(1,496)	(11,759)
	(594,004)	(68,384)
Ажлын капиталын өөрчлөлт:		
Дансны ба бусад авлагын өөрчлөлт	478,636	(518,371)
Бараа материалын өөрчлөлт	22,573	(19,659)
Урьдчилж төлсөн зардлын өөрчлөлт	(12,309)	(32,732)
Даатгалын гэрээний хойшлогдсон зардлын өөрчлөлт	34,201	(11,631)
Орлогд тооцоогүй хураамжийн нөөцийн өөрчлөлт	57,915	553,611
Учирсан боловч хэрэгжээгүй хохирлын нөөц ба болзошгүй хохирлын нөөцийн өөрчлөлт	625,435	438,804
Дансны ба бусад өглөгийн өөрчлөлт	(278,235)	125,382
	334,212	467,020
Төлсөн орлогын татвар	(128,831)	(125,811)
Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	205,381	341,209
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
Хүлээж авсан хүүгийн орлого	1,235,380	1,275,429
Худалдан авсан үндсэн хөрөнгө	(127,791)	(360,262)
Үндсэн хөрөнгө борлуулснаас хүлээж авсан мөнгө	4,497	18,000
Худалдан авсан биет бус хөрөнгө	(4,400)	-
Хугацаат хадгаламжийн өсөлт	(1,856,461)	(150,000)
Худалдан авсан засгийн газрын бонд	(1,015,610)	(299,994)
Засгийн газрын бонд борлуулснаас хүлээж авсан мөнгө	1,210,900	
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	(553,485)	483,173
Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
Хувьцаа гаргаснаас хүлээн авсан	-	750,000
Холбоотой талаас авсан санхүүжилт	750,000	-
Хувьцаа эзэмшигчдэд төлсөн ногдол ашиг	(166,667)	
Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	583,333	(322,222)
Мөнгөний үлдэгдэл дэх ханшийн зөрүүгийн нөлөөлөл	793	176
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн өсөлт	236,022	502,336
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	948,214	445,878
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	1,184,236	948,214



ХАРИЛЦАГЧДЫН
СЭТГЭГДЭЛ

ХАРИЛЦАГЧДЫН СЭТГЭГДЭЛ

Даатгалын түүх 1: Эд хөрөнгийн даатгал – Гал түймрийн эрсдэл. Даатгалын гэнэтийн ашиг тусын талаарх түүх.

"Миний ажил орой тардаг учраас би гэртээ дандаа оройтож харьдаг. Тухайн өдөр миний ажил эрт дууссан юм. Гэртээ ортол хүйтэн байсан тул гал түлэхээр шийдлээ. Би галаа асааж зуухандаа хэдэн нүүрс нэмж хийхэд гэр дулаацаж эхэлсэн бөгөөд зуухныхаа амыг нээлттэй орхиод нам унтчихаж. Гэнэт гадаа хүн орилох чимээнээр сэрж тэр даруй байшингаасаа гүйн гарахад дээвэр дээр гал авалцаж байсан. Нэг их удалгүй гал унтраах баг ирж галыг түргэн унтраалаа. Галыг унтарсан боловч миний шинэхэн барьсан байшингийн маань дүр зураг надад аймшигтай харагдсан. Дээвэр маш их гэмтсэн. Энэ үед гэнэт нэг зүйл санаанд оров. Манай хадам аав даатгалыг шүтэн бишрэгч бөгөөд намайг байшингаа даатгуул! гэж шаардсан хүн юм. Тэнгэр Даатгал руу утсаар ярьсны дараа төлөөлөгч ирж галын тохиолдлыг баримтжуулан нөхөн төлбөрийн маягт бөглүүлж явснаас хойш 2 хоногийн дараа ирсэн "Таны нөхөн төлбөрийн асуудал шийдвэрлэгдлээ. Баярлалаа. Тэнгэр Даатгал" гэсэн мессеж ирж билээ. Энэ үнэхээр намайг тайвшруулсан шүү."


Даатгалын түүх.2: Жолоочийнн хариуцлагын албан журмын даатгал. Тэнгэр Даатгалын үнэнч харилцагч болсон түүх.

"...Би халаалтын системийн инженер хүн. Даатгалын шинэ хууль гарсны дараа анх удаа даатгал авсан. Үнэн хэрэгтээ энэ шинэ хуулийн дагуу хүчээр даатгалд хамрагдсан учраас би бухимдалтай байсан.

2 жилийн өмнө, цагаан сарын шинийн нэгэнд хөгшчүүлдээ очиж золгохоор явж байх замдаа уулзварын эргэлтэн дээр нэг машиныг мөргөчихсөн. Эхлээд маш их айсан. Сар шинэ эхэлж байхад санхүүгийн асуудалд орсондоо өөрийгөө харааж байлаа! Замын цагдаа маш хурдан ирж ослын тайлан хөтөлсөн. Тэр надад даатгалын компани руугаа хурдан ярь гэж хэлээд яваад өгсөн. Би даатгалтай гэдгээ ойлгох үе аз жаргалтай мөч байсан. Би даатгалын дуудлагын төв рүү ярьж нөхөн төлбөрийн өргөдөл гаргах талаар дэлгэрэнгүй зааварчилгаа авсан.

Жижигхэн цаасны тусламжтайгаар би хохирлоо барагдуулж тухайн жилээс хойш "Тэнгэр Даатгал"-аар даатгуулж, даатгалын хугацаа дуусмагц байнга шинэчилдэг." болсон шүү! найзуудаа.





"CITY CENTER", 11 давхар,
Б.Алтангэрэлийн гудамж 5,
Ш/х-48/258
Улаанбаатар-14200

 www.tengerdaatgal.mn
 +(976)-1800-1889
 insurance@tengerinsurance.mn
 /tengerinsurance